



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 01 сарын 18 өдөр

Дугаар А/08

Улаанбаатар хот


Гэрчилгээний хураамж авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 6.11 дэх хэсэг, тус газрын дүрмийн 2.5.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа /зочид буудал, дэн буудал, жуулчны бааз, амралтын газар, гэр буудал/ эрхлэх зөвшөөрөл авч байгаа байгууллагуудаас гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийн хураамжийг 2017 оны 01 дүгээр сарын 18-наас авч эхлэхийг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-д даалгасугай.

2. Зөвшөөрөл авч байгаа байгууллагууд гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд шилжүүлсэн байдалд хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Г.Цэрэннадмид/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.БАТСҮХ

1150588188